

“Монад” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж  
буй хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дахь заалт, “Монад” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2008 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн шийдвэрийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.“Монад” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж байгаа нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 16.720.000 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэл, Хөрөнгийн биржийн бүртгэл, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х. Бум-Эрдэнэ/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2.“Монад” ХХК-ийн нийт хувьцааны 60 хувийг эзэмшигч иргэн П.Бүүвэйбаатарын эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцаа, хувьцаат компанийн 5.913.000 ширхэг хувьцаа, тус бүр 20 хувийг эзэмшигч иргэн А.Батсуурь, “Дархан холдинг” ХХК-ийн хувьцаа хувьцаат компанийн тус бүр 1.971.000 ширхэг хувьцаа болон хөрвөсөн тул өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

3.“Монад” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 6.865.000 ширхэг хувьцааг нийтэд санал болгон Хөрөнгийн биржээр арилжаалахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолын 2-т заасан нэр бүхий үүсгэн байгуулагчдын өмчлөлд бүртгэсэн хувьцааг үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс 1 жилийн хугацаанд тусгаарлаж хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулахгүй байхыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5.Үнэт цаас гаргах үйл ажиллагааны талаар олон нийтэд хандсан сурталчилгааг хангалттай сайн хийх, улмаар энэ тогтоолын 3-т заасан нийтэд санал болгон арилжаалах 6.865.000 ширхэг хувьцааны анхдагч зэх зээлийн арилжааг Хорооноос авсан зөвшөөрлийн үндсэн дээр эхлүүлэхийг “Монад” ХХК /Ж.Булган/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

6.Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа зохих журмын дагуу явагдаж дууссаны дараа тус Хорооноос зөвшөөрөл олгох хүртэл хувьцааны хоёрдогч зах

зээлийн арилжааг нээхгүй байх, хоёрдогч зах зээлтэй холбогдох гүйлгээг гүйцэтгэхгүй байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2

7.Энэ тогтоолын хавсралтаар баталсан товч танилцуулгын дагуу үнэт цаасыг нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангах, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Монад” ХХК /Ж.Булган/-д үүрэг болгосугай.

8.Нэг хөрөнгө оруулагчийн анхдагч зах зээлийн арилжаанаас худалдан авах хувьцааны захиалгын дээд хэмжээг 12500000 төгрөгөөс илүүгүй байхаар тогтоосугай.

9.Энэ тогтоолын 8-д заасан хязгаарыг баримтлан захиалга авахыг үнэт цаасны компаниудад, анхдагч зах зээлийн арилжааг хийхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д тус тус үүрэг болгосугай.

10.“Монад” ХХК нь хэлбэрээ өөрчлөн ХК болж буйгаа Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэхийг “Монад” ХХК /Ж.Булган/-д даалгасугай.

11.Хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан дотоод журмуудыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг “Монад” ХХК /Ж.Булган/-д үүрэг болгосугай.

12.Энэхүү тогтоол болон хавсралтыг ажлын 3 хоногийн дотор Хорооны веб хуудсанд байршуулахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

## **МОНАД ХХК-ИЙН ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА**

### **Танилцуулгын эхний хэсэг**

- 1. Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаархи мэдээлэл, судалгаа:**

Монад ХХК нь анх 2001 онд реклам, сурталчилганы чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 5 ажилтан, албан хаагчидтайгаар байгуулагдсан юм. Байгуулагдсан цагаасаа хойш өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах тал дээр байнга анхааран ажиллаж ирлээ. Ийнхүү хэрэглэгчээ дээдэлсэн, тэдний хэрэгцээ, шаардлагыг хангахуйц үйлчилгээ үзүүлж ирсэний үр дүнд өнөөдөр Монгол улсын хэмжээнд реклам, зар сурталчилгааны зах зээл дээр түргүүлэх, № 1 компани болон өргөжиж чадсан билээ.

Компаний явуулж буй үйл ажиллагааны үндсэн гол цөм нь Улаанбаатар хотын төв болон хөдөлгөөн ихтэй авто замуудын зорчих хэсгийн хажуугаар сурталчилгааны самбар байрлуулан, түүн дээрээ бизнесийн, олон нийтийн, төрийн болон бусад аж ахуй нэгж, байгууллагуудын реклам, сурталчилгааг байрлуулан иргэдэд таниулах явдал юм. Түүнчлэн үүний зэрэгцээ Улаанбаатар хот болон бусад томоохон төвлөрсөн суурин газруудад аж ахуйн нэгж, байгууллагуудын сурталчилгааны 4м\*9м, 5м\*12м . . .гм хэмжээ бүхий биллборд самбаруудыг захиалгаар хийж нийлүүлэх үйл ажиллагааг явуулдаг. Өнөөдрийн байдлаар захиалгын дагуу чанарын өндөр төвшинд 130 орчим биллборд самбар хийж нийлүүлээд байна.

Манай компаний үйл ажиллагааны үндсэн чиглэл болох авто замын зорчих хэсгийн хажуугийн сурталчилгааны самбар нь дараах 2 төрлийн хэмжээ болон загвартай байдаг. Үүнд:



Гэрэлт самбар \эргэлддэг\

Өргөн- 100 см

Өндөр- 140 см

Зузаан- 25 см

Суурь

Өргөн- 70 см

Өндөр- 50 см

Зузаан- 25 см

Хуудас харагдах талбай-  
90см\*130 см

5 хуудас ар араасаа

эргэлдэнэ.



Гэрэлт самбар

Өргөн- 82 см

Өндөр- 122 см

Зузаан- 18 см

Суурь

Өргөн- 50 см

Өндөр- 60 см

Зузаан- 18 см

Хуудас харагдах талбай-  
90см\*130 см

Энэхүү сурталчилгааны самбар нь өнөөгийн замын хөдөлгөөний нягтрал үлэмж ихэссэн, цаашид ч улам бүр ихсэх хандлагатай байгаа нөхцөлд түүн дээр байрласан аливаа сурталчилгаа нь иргэдэд хүрэх нь ТВ рекламьг эс тооцвол бусад рекламны сувгуудаас хэдэн хувь илүү байгаа юм.

Монад ХХК нь анх байгуулагдахдаа 30 ширхэг самбараар эхэлж байсан бол өнөөдөр Улаанбаатар хотод 1000 ширхэг самбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Түүчлэн хүний нөөцийн хувьд харьцангуй бага хүчээр их зүйл бүтээх боломжтой бөгөөд цаг үеийн байдалтай уялдаатайгаар одоогийн байдлаар нийт 22 үндсэн болон гэрээт ажилтан, албан хаагчидтай юм. Бид дээр дурьдсанчлан өөрийн үйлчлүүлэгчдийн хүсэл сонирхолд аль болох түлхүү анхаарч, гологдолгүй үйлчилгээ үзүүлж ирсэний үр дүнд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нийт компаниудын 90 орчим хувь нь нэг ба хэдэн арван давталттайгаар манай компанитай гэрээ байгуулан ажилласан байна. Үүнээс зарим нэг байнгын хэрэглэгчдийг дурьдвал Мобиком, Анод банк, Голомт банк, Скайтел, Юнител, Дэлхийн зөн, . . . гэх мэтээр хэдэн арван мөр, хуудас нэрс бичиж болох юм.

Ер нь реклам сурталчилгааны зах зээлд бидний ажигласнаар баримтлах гол зарчим бол чанартай, хэрэглэгч уруугаа хандсан үйлчилгээнээс гадна үйлчилгээ явуулж буй орон зай, цар хүрээ, түүнийг тархаах хүчин чадал ихээхэн нөлөөтэй байдаг. Иймд бид байгуулагдсан цагаасаа хойш самбар байрлуулах хамгийн ашигтай байрлалуудын талаар байнгын судалгааг зорчин өнгөрч буй тээврийн хэрэгсэл, тэдгээрийн багтаамж зэрэг дээр үндэслэн хийж ирсэн. Улмаар дээрх судалгаагаа үндэслэн ашигтай гэж дүн гарсан байрлалуудад албан ёсоор эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авсанаар самбаруудын тоогоо нэмсээр өнөөдөр 1000 ширхэг самбартай болсон нь нийт гудамжинд байрлах самбарын сурталчилгааны 85 орчим хувийг эзлээд байна.

Манай компани цаашид өөрийн үйл ажиллагааг орчин үеийн техник, технологийн үндсэн дээр хөгжүүлж, Монгол улсын реклам сурталчилгааны үйлчилгээг дэлхийн жижигт хүргэх зорилго тавин ажиллаж байна. Ингэснээр сурталчилгаа нь бизнесийг хөдөлгөх гол хүчин зүйлүүдийн нэг гэсэн маркетингийн онолын үүднээс манай аж ахуйн нэгжүүдийн бизнесийн, бусад байгууллагуудын үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж, үр ашиг нь дээшлэх юм. Энэ нь Монгол улсын ирээдүйн хөгжлийн хурдасыг нэмэгдүүлэхээс гадна наанадаж нийслэл хотын өнгө үзэмжийг нэмж байгаа нь бидний эх орныхоо хөгжилд оруулж буй хувь нэмэр гэж ойлгож байгаа болно.

#### 1.1 Компаний өнөөгийн байдал.

Монад ХХК нь хотын гудамж талбайд богино хугацаанд солих, засварлах боломж бүхий өөрийн самбаруудын зах зээлд анхдагч нь юм. Аливаа бизнест анхдагч байна гэдэг өөрийн зөв үйл ажиллагаагаар салбартаа тэргүүлэгч байх замыг засаж өгдөг. Манай компани ч гэсэн одоог хүртэл энэхүү гудамж, талбай дахь сурталчилгааны асар том зах зээл дээр тэргүүлэх байр сууриа хадгалсаар ирсэн бөгөөд цаашид ч энэ байдла хэвээр хадгалах тал дээр түлхүү анхааран ажиллаж байна.

Сүүлийн жилийн байдлаар самбарын ашигт үйлийн коэффициент 95 орчим хувьтай байгаа юм. Үлдэх ашиглагдахгүй байгаа 5 хувь нь манай нийгмийн байдлаас шалтгаалан 7 сарын сүүлч, 8 сарын эхэнд борлуулалт бага зэрэг буурдагтай холбоотой юм. Харин бусад саруудад самбарын ашиглалт бүрэн байдаг болоод байгаа ба энэ жилийн хандлагаас харахад уг самбаруудад сурталчилгаа байрлуулах гэрээ нь тогтмол цаг хугацаанаас түрүүлэн хийгдэж байна. Өмнөх жилүүдэд харьцангуйгаар нягтрал багатай газруудад 7 хоногоос 1 сарын хугацаанд сул явалт байдаг байсан бол одоо гэрээний захиалга, эрэлт нь самбарын нийт тооноос тогтмол хэтэрч байна. Энэ нь зах зээлийн өнөөгийн үсрэнгүй хөгжлийн үед улам нэмэгдэх

шинжтэй байгаа ба тухайн байрлалд нэг цаг мөчид байрлах сурталчилгааны тоог нэмэгдүүлэх боломжийг олгож байгаа юм.

Бид үйлчлүүлэгчийн сурталчилгааг байрлуулаад орхих биш түүнийг байнга арчилж, засаж сэлбэж байдгаараа бусад өрсөлдөгчдөөсөө давуу байдлыг илт үүсгэдэг. Иймч учраас компаний өнөөдрийн бизнесийн үйл ажиллагаа амжилттай явагдаж, орлого тогтмол нэмэгдэж байгаа юм.

Компани анх байгуулагдахдаа дээр дурьдсанаар 30 самбар, хэдэн ширээ, компьютер гэх мэт хомс хөрөнгөтэй байсан бол одоо үйл ажиллагаагаа хэнээс ч хараат бусаад явуулах боломжтой болоод байна. Үүнд зарим нэг зүйлсээс дурьдвал байнгын конторын ажилчид болон гүйцэтгэх ажлын байнгын орон тоотой болсон, өөрийн техникийн тоног төхөөрөмжүүд, автомашинтай болсон гэх мэт юм.

Компаний үйл ажиллагаа өргөжсөнөөр нээлттэй хувьцаат компани болох шийдвэр гарсан болно. Улмаар өөрийн хөрөнгийг үнэлгээний эрх бүхий компаниар хийлгэсэн нь биет болон биет бус хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч нь нийт 1 072 000 000 төгрөгөөр үнэлэгдээд байна. Энэхүү үнэлгээнд компаний биет бус хөрөнгө гэдэгт самбарын ашигтай байрлал, загварын үнэлгээ хамаарч буй юм. Ашигтай загварын хувьд Оюуны өмчийн газраас бүтээгдэхүүний загварын гэрчилгээ авахаар өргөдөл өгөөд байгаа ба татгалзсан хариу өгөгдөөгүй нь хуулийн хугацаанд гэрчилгээ олгогдоно гэж ойлгогдож байна.

Компани ийнхүү амжилттай ажиллаж цаашид улам үр бүтээлтэй байх нь нэгэнт тодорхой байгаа юм. Иймээс бид компаний дээд хэлбэр болох хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдаж, өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэн, шинэ техник технологи нэвтрүүлсэнээр цаашдаа хувьцаа эзэмшигчиддээ тогтмол ноогдол ашиг тараан ажиллах болно.

## **2. Үнэт цаас гаргагчийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, салбар төлөөлөгчийн газрууд, нэгжийн тухай танилцуулга:**

Компани нь байгуулагдсан цагаасаа хойш нэг хүний өмчлөлд байсан боловч бизнесийг өргөжүүлэх үүднээс нэмэлт хөрөнгө оруулалт оруулж 2005 оноос 3 гишүүнтэй болж өргөжсөн. Энэхүү хөрөнгө оруулалтаар хийгдсэн өргөжилт нь Улаанбаатар хотын хамгийн ашигтай байрлалуудад самбар зоож дуусгах, улмаар зах зээлээ бүрэн эзлэх боломжийг олгосон юм. Одоогийн байдлаар Монад хаалттай компаний хувьд хувь эзэмшигчид нь дараах байдалтай байна. Үүнд:

Но	Эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувь	ХК болсоноор эзэмших хувь
1.	П.Бүүвэйбаатар	60 хувь	38.47 хувь
2.	А.Батсуурь	20 хувь	12.82 хувь

3.	Дарханхан холдинг ХХК /итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Баттөр/	20 хувь	12.82 хувь
----	--	---------	------------

Ажилтан албан хаагчдын хувьд удирдлагын төвшины ажилтан, гүйцэтгэх ажилтан гэж хоёр ангилагддаг. Удирдах төвшины ажилтануудын хувьд тогтмол тоотой ба харин гүйцэтгэх ажилчид нь тухайн үеийн ажлын онцлогоос шалтгаалж хэлбэлзэж байдаг.

Дараах бүдүүвчээс компаний ерөнхий зохион байгуулалтыг харж болох юм.



Энэхүү ерөнхий зохион байгуулалт нь одоогийн явуулж байгаа үйл ажиллагааны төвшингөөр бөгөөд бидний тавьж буй зорилгын дагуу хийгдэх үйлчилгээ нэмэгдсэнээр шинээр зарим ажилтан албан хаагчид бий болох юм.

### 3. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар:

Монад ХХК-ийн дүрэм болон хувьцаат компаний дүрмийн төслийг хавсаргав.

### 4. Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр. Хэрэв уг үнэт цаасыг гаргах нь тухайн компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохоор бол шийдвэрийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргасан тухай мэдээлэл:

Монад ХХК -ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2007 оны 11 сарын 14 ны өдрийн 07\10 тоот тогтоол, компанийн тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлийн заалтуудыг тус тус үндэслэв.

5. Сангийн сайдын 2004 оны 12 сарын 22-ны өдрийн 248 тоот тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар", Хорооноос баталсан "Үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын тайланд нэмэлт тодруулга бэлтгэх журам"-д заасан нэмэлт тайлбар тодруулгыг бүрэн тусгасан сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэхээр зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улиралын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан:

*Монад ХХК-ийн 2005, 2006, 2007 онуудын жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажсан тайлангуудыг хавсаргав.*

6. Үнэт цаас гаргагч компани болон түүний толгой, охин компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй болох талаар банкны өр барагдуулах алба, харилцагч банкны тодорхойлолт:

*Монад ХХК нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй бөгөөд харилцагч банкны болон банкны өр барагдуулах албаны тодорхойлолтыг хавсаргав.*

7. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэн баталгаажуулсан материал:

*Хөрөнгийн үнэлгээний төв ХХК-ийн УБГ дугаар 35/3526, 2545411 тоот регистрийн дугаартай. Самбуугийн гудамж-11, Улаанбаатар 38, Утас 325127 Монад ХХК-ийн бизнесийн үнэлгээний тайланг хавсаргав.*

8. Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамж төлсөн баримт:

*Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамжийг төлсөн баримтыг хавсаргав.*

## **Танилцуулгын хоёрдахь хэсэг**

1. Үнэт цаасны төрөл, хэлбэр:

- a. Үнэт цаасны төрөл: *Энгийн хувьцаа*  
b. Үнэт цаасны хэлбэр: *Биет бус*

2. Үнэт цаас эзэмшигчийн эрх:



Хувьцаанд хөрвүүлсэн үнэт цаасаа МХБ-д бүртгүүлэн өөрийн нэрийн дансанд байршуулсан болон МХБ-ээр дамжуулан "Монад" энгийн хувьцааг худалдан авч өмчилсөн байгууллага, иргэн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 1) Хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр худалдах;
- 2) Хувьцаагаа барьцаалах, бэлэглэх;
- 3) Компанийн нэмж гаргасан энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.
- 4) Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон “бүртгэх өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрх бүхий хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
- 5) Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд, ТУЗ-ийн шийдвэрт заасан хугацаанд олгоогүй бол алданги төлөхийг шаардах эрхтэй.
- 6) Компанийг татан буулгах үед “Компанийн тухай” хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.
- 7) Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
- 8) Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
  - a. Нийтлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх;
  - b. Хэлцэл хийхийн өмнө сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн;
  - c. Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай

Компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг баталсан;

- d. Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- e. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 хоног ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
- f. Хувь нийлүүлэгч нь “Компанийн тухай” хуулийн 66.4-т заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.
- g. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй.

### **3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график:**

- a. Монад ХХК-ийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа МХБ болон ҮЦГТТХТ ХХК-тай хийсэн гэрээний дагуу үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалах бөгөөд эхний нийлүүлэлтийг МХБ ХК-ийн данснаас 6 000 000 ширхэгийг 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэйгээр нийлүүлнэ.
- b. Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд андеррайтер, брокер дилерийн синдикат үүсгэж санал болгох замаар хувьцааг байриуулна.
- c. Анхдагч зах зээл дээр 2008 оны 05 дугаар сарын 01 оос 2008 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд байриуулж арилжаална.
- d. Анхдагч зах зээлд нийлүүлэх хувьцааны үнэ:  
Нэгжийн үнэ 100 төгрөг,  
Нийт 600 000 000 төгрөг
- e. Үнэт цаасны арилжааны мэдээг [www.olloo.mn](http://www.olloo.mn) болон МХБ-ийн вэбсайтаас ([www.mse.mn](http://www.mse.mn)) авч болно. Түүнчлэн өөрийн данс бүхий брокер, дилерийн компаниуд болон зөвлөх Би Си Консалтинг ХХК-иас 99110137 тоот утсаар арилжааны мэдээллийг авч болно.

- 4. Урьд үнэт цаас гаргаж байсан эсэх, үнэт цаасны нэр төрөл, гаргасан огноо, нийт хэмжээ, төлөгдөх буюу төлөгдсөн хэмжээ, өрийн бичиг гаргасан бол үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж байсан тухай үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт:**

*Монад ХХК нь урьд өмнө нь өрийн бичиг болон энгийн хувьцааг гаргаж байгаагүй болно.*

- 5. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төсөл, эдийн засгийн үр ашгийн тооцоо:**

- a. Одоогийн хувь эзэмшигчид нь компаний дахин үнэлгээнд үндэслэгдсэн өөрсдийн хөрөнгийг энгийн хувьцаанд хөрвүүлэн ҮЦТТХТ ХХК дахь нэрийн дансандаа байршуулна.*
- b. Нэмж гаргаж буй 100 төгрөгний нэрлэсэн үнэ бүхий 6 000 000 ширхэг хувьцааг арилжаалснаар хуримтлагдах хөрөнгийг компаний үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор компанид хөрөнгө оруулалт болон зарцуулагдана. Энэхүү компанийг өргөтгөх үйл ажиллагааг явуулснаар компаний ашиг орлого үлэмж нэмэгдэж, хувьцаа эзэмшигчидийн хөрөнгө өсөх ба энэ талаарх бизнес төлөвлөгөө, санхүүгийн тооцоог хавсаргасан болно.*

- 6. Үнэт цаасыг арилжаалахад санал болгох хүрээ:**

- a. Дотоодын томоохон хөрөнгө оруулагч нар авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.*
- b. Нийт брокер диллерийн компаниуд, тэдгээрийн харилцагч нарт санал болгоно.*
- c. Хувьцааны талаарх мэдээллийг олон нийтийн радио телевиз, өдөр тутмын сонин, рекламны самбар, интернетээр дамжуулан нийт ард иргэд болон байгууллагуудад хүргэнэ. Улмаар арилжааны талаарх мэдээллийг дээрх цувгуудаар дамжуулан тогтмол мэдээнэ.*

- 7. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ:**

*Монад компаний энгийн хувьцааг худалдаж авснаар хөрөнгө оруулагчид дараах зүйлүүд дээр анхаарч үзнэ үү.*

*Дараах эрсдэлүүд компаний хувьд бодитойгоор оршин тогтмнох боломжтой байна. Үүнд:*

- НЗАА-наас хулдаасан самбарыг хориглож болиулах хандлагатай байгаа учраас манай компанийг бүх самбараа солиж амжихаас өмнө энэхүү шийдвэр гарвал бид санхүүгийн хүндрэлд орж болзошгүй*
- Ажиллах хүчний хөдөлгөөн нэмэгдэж чадварлаг, мэргэжлийн боловсон хүчин дайжих*

- Компаний үйл ажиллагаа нь НЗАА-ны бодлогоос шууд хамааралтай учраас эмзэг байдлыг үүсгэдэг

Өнөөдөр манай компани хэдийгээр өргөн боломжтой зах зээл дээр хамгийн их хэрэглэгчдийн анхаардын төвд байдаг сурталчилгааны компаниудын нэг боловч үүнд тайвшран суух нь туйлын буруу юм. Бид одоо байгаа үйлчилгээндээ сэтгэл ханах биш шинэ шинэ дэвшилтэт технологиудыг ашиглан үйлчилгээгээ улам бүр боловсронгуй болгох хэрэгцээтэй гэж үзэж байна.

**8. Үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаар төлөвлөж байгаа бол байгуулах гэрээний төсөл, өөрөө анхдагч зах зээлд худалдах бол мэдээллийг нийтэд сурталчлах журам, төлөвлөгөө:**

Монад ХХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгохоос долоо хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн хувьцааг гаргах өдөр болон бусад нөхцлийн тухай мэдээлнэ.

Мэдээдллийг олон нийтэд хүргэхдээ маркетингийн үйл ажиллагааг идэвхижүүлэн доорхи үе шатуудаар дараалан арга хэмжээ авна.

- Хэвлэлийн бага хурал
  - ◆ Аль нэг хэвлэл мэдээллийн албатай хамтран хэвлэлийн бага хурал хийнэ.
- Олон нийтэд санал болгох

	Мэдээллийн хэрэгслийн нэр	Сурталчилгааны давтамж	Бусад тайлбар
1	Өдрийн сонин	2 удаа	1 удаад 200 000 ₮
2	Зууны мэдээ	2 удаа	1 удаад 200 000 ₮
3	MTB	7 хоногт 2 удаа	1 удаад 90 000 ₮
4	TV9	7 хоногт 2 удаа	1 удаад 45 000 ₮
5	FM Элгэн нутаг	7 хоногт өдөр бүр	1 удаад 2 500 ₮
6	FM-101.7	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500 ₮
7	FM 102.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3500 ₮
8	FM-104.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500 ₮
9	Монголын Радио	7 хоногт өдөр бүр	1 удаад 3500 ₮

10	FM-98.9	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
11	FM-100.1	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
12	FM-107.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮

- Хөрөнгийн биржийн мэдээллийн албатай хамтран ажиллах,
  - ♦ Хөрөнгийн зах зээл сэтгүүлд зар тавих
  - ♦ Хөрөнгийн бирж болон Оллоо ХК-ийн цахим хуудас дээр мэдээлэл тавьж ярилцлага байршуулах
- Томоохон аж ахуйн нэгж байгууллагуудад санал тавих
- ♦ Хөрөнгө оруулагч нарт зориулсан тусгай presentation болон танилцуулга брошур бэлдэн танилцуулах,
- ♦ МХБ-ийн гишүүн брокер диллерийн компаниудаар дамжуулан тэдгээрийн харилцагч нарт мэдээлэл хүргүүлнэ.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.3, 7.4-Д ЗААСАН МЭДЭЭЛЭЛ

### 1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Монад ХХК, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Таван эвтэн ХХК-ийн байр  
 Утас: 976-11-305484, 99110137  
 Факс: 976-11-305484  
 Имайл: monad@olloo.mn

### 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар:

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.

### 3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаарх мэдээлэл:

№	Нэрс	Регистр	ИҮ дугаар	Эзэмшиж буй хувь	Хувьцааны тоо	ХК болох үед эзэмших хувь
1	П.Бүүвэйбаатар	ЧД73052677	УБ0629828	60%	6 432 000	38.47%
2	А.Батсуурь	УЖ63111011	УБ0074647	20%	2 144 000	12.82%
3	Дарханхан холдинг ХХК \итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Батгөр	2768801	23\1508	20%	2 144 000	12.82%

**4. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь уг үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг эзэмшдэг бол түүний хувь хэмжээ:**

№	Нэрс	Албан тушаал	Эзэмшиж буй хувь	Хувьцааны тоо	ХК болох үед эзэмших хувь
1	П.Бүүвэйбаатар	ТУЗ-ийн дарга	60%	6 432 000	38.47%
2	А.Батсуурь	ТУЗ-ийн гишүүн	20%	2 144 000	12.82%
3	Дарханхан холдинг ХХК \итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Баттөр	ТУЗ-ийн гишүүн	20%	2 144 000	12.82%

**5. Үнэт цаас гаргагчийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан санхүүгийн тайлан, өр, зээлийн талаархи мэдээ:**

**Санхүүгийн үзүүлэлтүүд**

*Компанийн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлангуудын хураангуйг доорхи хүснэгтэд харуулав.*

	2005	2006	2007
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>218,119.5</b>	<b>213,800.2</b>	<b>65,117.8</b>
Мөнгөн хөрөнгө	7,332.4	127,584.2	19,577.2
Авлага	190,250.6	85,532.1	39,660.3
Бараа материал	20,536.5	683.9	5,880.3
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>283,022.3</b>	<b>268,210.5</b>	<b>1,045,133.6</b>
Тоног төхөөрөмж	305,054.2	338,215.1	457,746.0
Элэгдэл	- 27,615.2	- 76,003.6	- 11,556.3
Тавилга, эд хогшил	5,924.7	6,991.0	5,069.9
Элэгдэл	- 341.4	- 1,007.9	- 223.7
Биет бус хөрөнгө	-	16.0	609,331.0
Элэгдэл			- 15,233.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>501,141.8</b>	<b>482,010.7</b>	<b>1,110,251.4</b>
<b>Эх үүсвэр</b>			
<b>Нийт өр төлбөр</b>	<b>281,517.2</b>	<b>374,117.2</b>	<b>77,277.9</b>
Дансны өглөг	29,543.8	6,625.8	26,590.9
ААНБОАТ-ын өглөг	-	1,119.3	5,167.4
ХАОАТ-ын өглөг	648.0	229.1	- 494.1
НӨАТ-ын өглөг	7,565.2	4,712.5	795.4
ЭМНД-ын шимтгэл	721.7	77.9	- 123.0
Банкны зээл	219,924.2	330,000.0	-
Урьдчилж орсон орлого	23,114.3	20,271.6	45,341.3
Бусад өглөг	-	11,081.0	-
<b>Эздийн өмч</b>	<b>219,624.5</b>	<b>107,893.5</b>	<b>1,032,973.5</b>
Хувийн	261,000.1	292,000.1	650,000.0
Дахин үнэлгээний нөөц			557,534.3
Хуримтлагдсан ашиг/алдагдал			
Тайлангийн үеийн		4,403.6	90,947.6
Өмнөх үеийн	- 41,375.6	- 188,510.2	- 265,508.4
<b>Нийт эх үүсвэр</b>	<b>501,141.8</b>	<b>482,010.7</b>	<b>1,110,251.4</b>

2005 оны эцсээс 2007 оны 4 дугаар улирлыг хүртлэх хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 2.21 дахин өсчээ. Дансны өглөгийн хувьд богино хугацаат нийгмийн даатгалын болон хүн амын орлогын албан татварын өглөг байгаа бөгөөд өр төлбөр эзэмшигчдийн өмчийн 7.48 хувийг эзэлж байгаа нь Монад ХХК өр төлбөрийн хувьд бага байна. Монад ХХК нь богино хугацаанд борлуулалтаа нэмэгдүүлэн, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлуудаа хэмнэж чадсанаар ашигт ажиллагаагаа нэмэгдүүлсэн юм. Түүнчлэн цаашид бизнес төлөвлөгөөгөө хэрэжүүлснээр орлого ашгаа үлэмж нэмэгдүүлэн, тогтмол ногдол ашиг тараах бүрэн боломжтой юм.


### Орлого үр дүнгийн тайлан

	2005 он	2006 он	2007 он
<b>Борлуулалтын орлого</b>	<b>81,108,739.13</b>	<b>147,905,289.38</b>	<b>330,090,578.37</b>
ББӨ	29,975,810.99	78,728,629.18	145,138,145.55
<b>Нийт ашиг</b>	<b>51,132,928.14</b>	<b>69,176,660.20</b>	<b>184,952,432.82</b>
<b>Ү.а-ний нийт зардал:</b>			
Үндсэн болон нэмэгдэл цалин	4,384,540.00	4,492,555.43	10,389,822.48
НДШ	876,908.00	898,511.09	2,077,964.5
Засвар үйлчилгээний зардал		44,100.00	
Тээврийн болон албан томилолтын зардал	10,242,466.00	35,000.00	35,000.0
Түүхий эд материалын зардал		152,840.00	
Элэгдлийн зардал	150,461.64	666,551.88	751,382.7
Зар сурталчилгааны зардал		575,000.00	
Шуудан холбооны зардал	661,652.17	684,194.07	7,352,675.31
Шатахууны зардал	-	552,660.88	4,247,322.72
Зээлийн хүүний зардал	32,675,690.38	46,025,419.54	44,368,443.48
Бусад зардал	18,086,756.03	7,128,646.93	12,473,358.67
<b>Үндсэн үйл ажиллагааны нийт зардал</b>	<b>67,078,474.21</b>	<b>61,255,479.82</b>	<b>81,695,969.87</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>(15,945,546.08)</b>	<b>7,921,180.38</b>	<b>103,281,101.3</b>
Татварын зардал	-	1,188,177.06	10,328,110.13
Татварын дараах ашиг /алдагдал/	(15,945,546.08)	6,733,003.31	92,952,991.17
Ногдол ашиг	-	-	-
Онцгой шинжтэй зүйлс	(560,573.35)	(2,329,354.00)	(2,005,402.00)





<i>Цэвэр ашиг алдагдал</i>	<i>(16,506,119.43)</i>	<i>4,403,649.32</i>	<i>90,947,589.17</i>
----------------------------	------------------------	---------------------	----------------------

Эндээс борлуулалтийн орлогын өсөлтийг графикаар харуулая.



Одоо нийт хөрөнгийн болон цэвэр ашгийн өөрчлөлтийг графикаар харья.



2007 онд гаргах үр дүнг 4-р улирлын байдлаар борлуулсан бүтээгдэхүүний өртөг нийт борлуулалтын 44 орчим хувийг эзэлж байна. Нийт зардлын 12.7 орчим хувийг ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлс болон боловсон хүчин бэлтгэх зардал, 9 хувийг шуудан холбооны зардал тус тус эзэлж байна.

#### **6. Компанийг өөрчлөн зохион байгуулах, үнэт цаас гаргахад зөвлөгөө өгөх байгууллагын тухай мэдээлэл:**

Компанийг өөрчлөн зохион байгуулахад зөвлөхөөр ажиллаж буй "Би Си Консалтинг" ХХК нь 2003 онд санхүү эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, хуулийн этгээдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор байгуулагдсан.

Бидний зорилго, үйл ажилгааны үндсэн чиглэл:

Тус компани нь шударга ёсыг хангах, үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн хүрээнд бүрэн, тууштай хамгаалж, тэдэнд мэргэжлийн өндөр түвшинд, түргэн шуурхай үйлчлэх зарчмыг баримтална.

Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдийн бизнесийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, лавлагаа гаргах, Аж ахуйн нэгж байгуулах, өөрчлөх, татан буулгах талаар зөвлөгөө өгөх, холбогдох баримт бичгийг боловсруулах, Бизнесийн зөвлөгөө, төлөвлөлт, сургалт, судалгаа явуулах, Төсөв, тайлан тэнцэл, төсөл боловсруулах зэрэг санхүү, эдийн засгийн асуудлуудаар мэргэжлийн зөвлөгөө өгнө.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хууль, эрх зүйн акт, шаардлагатай мэдээллээр үйлчилж, лавлагаа өгөх, Дүрэм, журам, гэрээ, албан бичиг, төсөл бусад баримт бичгийн эх бэлтгэж туслах, Холбогдох байгууллага /хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүх арбитр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, татвар, бусад байгууллага/-д төлөөлж, өмгөөлөл хийх зэрэг хууль эрх зүйн бүхий л асуудлаар эрх зүй туслалцаа үзүүлнэ.

Бидний хийж бүтээсэн ажил:

"Би Си Консалтинг" ХХК нь байгуулагдсан цагаасаа хойш давхардсан тоогоор 1000 илүү иргэд, 80 орчим аж ахуйн нэгж, хуулийн этгээд, 10 гаруй гадаадын хөрөнгө

оруулалттай аж ахуйн нэгжид санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлсэн болно.

Бидний давуу тал:

Гадаад, дотоодод өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн чадварлаг залуусаар багаа бүрдүүлсэн.

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, их дээд сургуулиудад олон жил үр бүтээлтэй ажилласан эрдэмтэн, судлаачдын зөвлөх багтай.

Компаний байрлал хотын төвд, үйлчлүүлэгчдэд ойр Тохилог орчин, сүүлийн үеийн мэдээлэл, программ, хэрэгслүүдийг өргөнөөр ашигладаг

## 7. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл:

Бусадтай байгуулсан их хэмжээний гэрээ хэлцэл байхгүй болно.

/мян.төг-өөр/

Балансын зүйл	Үлдэгдэл		
	2006 он	2007 он	2008 оны 1-р улирал
<b>А.Хөрөнгө</b>			
<b>1.Эргэлтийн хөрөнгө</b>	<b>213,800.20</b>	<b>65,117.80</b>	<b>52,930.40</b>
Мөнгөн хөрөнгө	127,584.20	19,577.20	23,639.30
Богино хугацаат хөрөнгө оруулалт			
Авлага	85,532.10	39,660.30	5,737.70
Бараа, бэлэн бүтээгдэхүүн			
Үндсэн ба туслах материал	683.90	5,880.30	5,198.30
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			18,355.10
Эрсдлийн сан			
<b>2.Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>268,194.50</b>	<b>451,035.90</b>	<b>439,184.10</b>
Үндсэн хөрөнгө	345,206.00	462,815.90	462,702.00
Хуримтлагдсан элэгдэл	(77,011.50)	(11,780.00)	(23,517.90)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө			
<b>3. Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>16.00</b>	<b>594,097.70</b>	<b>594,097.70</b>
<b>4. Урт хугацаатай хөрөнгө оруулалт</b>			
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>482,010.70</b>	<b>1,110,251.40</b>	<b>1,086,212.20</b>
<b>Б. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>			

<b>1. Өр төлбөрийн дүн</b>	<b>374,117.30</b>	<b>77,277.90</b>	<b>86,447.10</b>
Богино хугацаат өр төлбөр	374,117.30	77,277.90	86,447.10
Урт хугацаат өр төлбөр			
Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр			
<b>2. Өмчийн дүн</b>	<b>292,000.00</b>	<b>650,000.00</b>	<b>650,000.00</b>
а. Төрийн			
б. Хувийн	292,000.00	650,000.00	650,000.00
<b>3. Хувьцааны дүн</b>			
Энгийн хувьцааны тоо ширхэг			
Нэрлэсэн үнэ			
Давуу эрхтэй хувьцааны тоо ширхэг			
Нэрлэсэн үнэ			
Халаасны хувьцааны дүн			
Дахин үнэлгээний нөөц		557,534.30	557,534.30
<b>4. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг</b>			
<b>5. Хуримтлагдсан ашиг:</b>	-184,106.60	-174,560.80	-207,769.20
<b>6. Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>107,893.40</b>	<b>1,032,973.50</b>	<b>999,765.10</b>
<b>7. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>482,010.70</b>	<b>1,110,251.40</b>	<b>1,086,212.20</b>

Ногдол ашиг тараасан онууд

2006

2007

Нэгж хувьцаанд оногдуулсан ногдол ашиг  
/төг/

/мян.төг-өөр/

Үзүүлэлт	2006 он	2007 он	2008 оны 1-р улирал
<b>1.Цэвэр борлуулалт</b>	<b>147,905.30</b>	<b>330,090.60</b>	<b>93,207.70</b>
<b>2.Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг</b>	<b>78,728.63</b>	<b>145,138.10</b>	<b>66,862.60</b>
<b>3.Үйл ажиллагааны зардал</b>	<b>61,255.50</b>	<b>81,696.00</b>	<b>22,474.70</b>
<b>4. Ашиг</b>	<b>7,921.17</b>	<b>103,256.50</b>	<b>3,870.40</b>
<b>5. Хувьцааны арилжааны дундаж ханш</b>			
<b>6. Хувьцааны дансны дундаж ханш</b>			
<b>7. Хувь нийлүүлэгчдийн тоо</b>	3	3	3
<b>8. Хувьцааны төвлөрлийн хувь</b>			